



ТӨВ АЙМАГ
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/105

Бүрэн сум

Гочхалдварт өвчөөс урьдчилан сэргийлэх
вакцин тарих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3,(а) дахь заалт, 29.2 дахь хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.5, 6.6 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт Шүлхийн вакциныг 2021 оны 09 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн 2021 оны 09 дүгээр сарын 30-ны хооронд төлвөлгөөт хугацааны дагуу хийж дуусгахыг Мал эмнэлгийн нэгжийн эмч нарт, уг ажилд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (С.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

2. Мал бүхий иргэдтэй гэрээ хийж, халдварт өвчний вакциныг тарьж дуусгах ажлыг зохион байгуулж, өрхийн дэвтэрт хөтлөлт хийж, баталгаажуулах ажлыг Түмий, Баясгалан-Уул, Сайн Цохио, Арцат Баянгүн, Баялагсүрэг Баянтөхөм Хариуцлагатай Хувьцаат Компанийн малын эмч (Д.Цэрэндаваа, Б.Дэлгэрнасан, Д.Хасбазар, Л.Сарантуяа, Д.Оюунтуяа) нарт даалгасугай.

3. Тарилгын явцад хяналт тавьж, хүн хүчний тусламж үзүүлж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.ТҮВШИНБАТ

410500277